

ШИНЭ ҮЕИЙН ФИЛОСОФИ ДАХЬ ЦАГ ХУГАЦААНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ

Г.Эрдэнэбаяр, МУИС, НШУС, Философийн тэнхим, доктор.
Ц.Эрдэнэбат, ХААИС-ийн багш, докторант

Түлхүүр үг: орон зай, ахуй, "оршихуйн эмх цэгц",

Энэ үед байгалийн шинжлэх ухаанд олон томоохон нээлтүүд хийсэн Н.Коперник, Кеплер, Г.Галилей болон И.Ньютон гэх мэт дөрвөн сэтгэгчдийг гарцаагүй нэр дурдах хэрэгтэй. Тухайлбал, "Нар нь ертөнцийн төв, нарыг тойрон дэлхий эргэдэг" гэж Н.Коперник (1473-1543) астрономын онолыг батлан, цаашдын шинжлэх ухааны хөгжилд чухал нөлөө үзүүлсэн. Түүнчлэн тэр үед худалдаа боловсронгуй болон, техникийн ухаанд дэвшил гаран, уурын машин зохиогдон, математик, астрономи, геометр, физикийн хөгжилд ахиц гарсан үе юм. Эдгээр нээлт ололт нь философи дахь цаг хугацааны талаархи ойлголтыг өргөжүүлэн гүнзгийрүүлэхэд чухал үндэслэгээ болжээ.

Тэр үеийн философичдоос цаг хугацааны талаар тайлбарласан сэтгэгчид цөөнгүй байдгийн дотор Английн философич Т. Гоббс (1588-1679) юм. Т.Гоббс "Биеийн тухай", "Хүний тухай", "Левиафан" зэрэг бүтээл туурвисны зэрэгцээ "Нийгмийн гэрээний онол" болох нийгэм улс төрийн талаар өөрийн үзэл санаагаа дэвшүүлж байжээ.

Т.Гоббс орон зай болон цаг хугацааны шинжийн талаар "Биеийн тухай" бүтээлдээ өгүүлэн, бодит орон зай эзлэгч эсвэл тоо байдаг гэдгийг авч үзсэнээрээ энэ нь хүний ухамсраас үл хамааралтайг дурдсан хэрэг юм.. Орон зай нь бидний оюун ухаанд төсөөлөл болон оршдог. Энэ төсөөлөл эсвэл сэтгэгдэл, биеийн дүрс хэмжээс нь хийсвэр, бодит орон зайгаас ялгаатайг Т.Гоббс орон зай гэж нэрлэсэн¹. Т.Гоббс үүнтэй адил цаг хугацааны асуудлыг шийдэх оролдлого хийсэн.

Тэрээр "Хөдөлж буй, бидэнд нөлөөлж буй байдал нь түүний хөдөлгөөний тухай, биеийн тухай, тасралтгүй хувирч байдаг талаарх төсөөлөл нь бидний ухамсарт өдөөгдөж байдаг. Би үүнийг цаг хугацаа гэж нэрлэж байна. Цаг хугацаа нь бүхий л зүйлсэд биш, харин бидний оюун ухаан сэтгэхүйд оршин байдаг"² гэдгийг дурдаад, цаг хугацааны бүрэн тодорхойлолт нь: Цаг хугацаа хөдөлгөөний хэлбэр болдог. Учир нь бид хөдөлгөөнд "эрт", "орой" хэмээн төсөөлж боддог³ хэмээн үзсэн нь хожуу үеийн зарим философичдод идеалист концепц гэж шүүмжлүүлсэн байдаг.

Цааш нь, Т.Гоббс: "Бидний өмнөх үеийнхний цаг хугацааны талаар жишээлэн ярихдаа бид тэднийг үхсэний дараагаар эдгээр цаг хугацаа нь өмнөх үеийнхнийг дурсах ой санамжинд, өөрөөр орших боломжтой гэдгийг боддоггүй. Хэрвээ нар болон сарны хөдөлгөөнөөс бидний он цаг тоолол нь хамааралтай гэж үзвэл гарцаагүй ямар ч цаг хугацаа байдаггүй, байгаа ч үгүй, байхгүй ч байх болно гэсэн дүгнэлтэд хүрнэ"⁴ гэж үзсэн.

¹ "История философии". т II. Огизгосполиздат, 1941. с.114

² Гоббс. Т "Избранные сочинение".с.73

³ Соколов. В. В "Европейская философия XV-XVII веков". М, 1984. с.289

⁴ Соколов. В. В "Европейская философия XV-XVII веков". М, 1984. с.289

Бидний биеийн хөдөлгөөнөөс орон зай болон цаг хугацаа нь хамааралтай байдаг талаарх Т. Гоббсын үзэл санаа нь орчин үеийн физикийн шинжлэх ухааны зарим дүгнэлтийг урьдчилан төсөөлсөн гэж Оросын эрдэмтэн Соколов үздэг. Т.Гоббсын философи дахь цаг хугацааны талаар өгүүлсэнийг дүгнэвэл тэрээр цаг хугацааг цэвэр субьектив үзэгдлийн шинжтэй хэмээн тайлбарлажээ.

Тэрчлэн цаг хугацааны талаар философийн тайлбарлал өгсөн тэр үеийн сэтгэгчидийн нэг нь П.Гассенди (1592-1655) юм. П.Гассендийн хувьд цаг хугацаа болон орон зайг субьектив байдлаар авч үзсэн. Түүний үзлээр, "Орон зай бол матери, тэрчлэн бурхан тэнгэрээс үл хамааран оршдог,... Орон зай нь биет бус, үл хөдлөх, хил хязгаар, зааг гэж үгүй,...бурхан тэнгэрээс гадна субстанции устаж болох ч орон зай бол үл устах шинжтэй, орон зай бол ямар нэгэн субстанцын модус биш, учир нь модус нь субстанцын оршихуйд хамааралтай байдаг. Орон зай нь түүнээс үл хамааран байдаг¹ ажээ.

Түүний үзлээр цаг хугацаа гэдэг бол объектив бус, энгийн төсөөлөл ч биш. Учир нь цаг хугацаа нь аливаа ертөнцөд ямар нэгэн утга санаа байхгүй болсон ч цаг хугацаа л оршин байсан. Цаг хугацаа гэдэг бол юу ч биш гэдгийг үгүйсгэхдээ тэр нь одоо болон өнгөрсөнд үл мэдэгдэх агшнаас бүрддэг, цаг хугацаа нь ирээгүй байгаа ирээдүйд оршин байдаггүй² гэж П.Гассенди өөрийн үзлээ гаргахын тулд тэр үеийн сүм хийд шашинд үл эсэргэлцэх байдлаар орон зай болон цаг хугацааг субстанции биш болохынх нь хувьд сургасан байв.

Орон зайн тухай П.Гассендийн сургаал нь атомуудын хөдөлгөөн нь хоосон орон зайд боломжтой гэж үзэх атомист концепцтэй нягт холбоотой. П.Гассенди материас орон зай болон цаг хугацааг салгаад, орон зай болон цаг хугацаа нь материйн үндсэн шинж биш гэж үзсэн.

Мөн цаг хугацааны талаар тайлбар өгсөн өөр нэг сэтгэгч бол шинжлэх ухаан болон техникийн хөгжлийг дэмжихийг уриалагч, шашныг шүүмжлэгч, ертөнцийн аливаа үзэгдэл, юмсыг "монада"-н үүднээс холбон тайлбарладаг XVII зууны үеийн сэтгэгч Г. Лейбниц (1646-1716) юм.

Түүний үзлээр, "орон зай болон цаг хугацаа нь "оршихуйн эмх цэгц" гэж үзсэн. Орон зай нь хамтран оршихуйн эмх цэгц, харин цаг хугацаа нь дараалан, цувран оршихуйн эмх цэгц,хэлбэр"³ юм. Лейбниц Ньютоноос өөрөө орон зай болон (материаллаг зүйлсээс үл хамаарах) цаг хугацааны туйлын оршихуйг үгүйсгэн, тэдгээрийн харьцангуй шинжийг нь батлан: хэрвээ бүтээгдсэн зүйлс гэж байгаагүй бол орон зай болон цаг хугацаа гэж байхгүй байх байсан, иймээс бодит орон зай гэж байхгүй⁴ гэж үзсэн буй.

Г.Лейбниц орон зай болон цаг хугацааны субстанцлаг шинжийг үгүйсгэдэг ч, тэдгээрийг ертөнцийн үзэгдлийн салшгүй атрибут шинж гэж үзэн, объектив шинжийг нь үгүйсгээгүй болно. Иймээс орон зай болон цаг хугацааны тухай Лейбницийн сургаал нь объектив идеалист шинжтэй бөгөөд

¹ "История философия". т II. Огизгосполиздат, 1941. с 157

² Там же. С.157

³ "История философия". т II. Огизгосполиздат, 1941.с. 207

⁴ Там же. С.208

орон зай болон цаг хугацааг материаллаг бус, өөрөө өөрийнх нь оюун болох "монад" —н үзэгдлийн хүч¹ хэмээн сургасан.

XVII зууны сэтгэгчидийн дотроос цаг хугацааны талаар дорвитой авч үзсэн сэтгэгч бол И.Ньютон юм. Тэрээр гарамгай физикч, математикч хүн бөгөөд сонгодог механикын хуулийн үндсийг бүтээж, хязгааргүй багц тоолол болон бүх дэлхийн таталцлын хуулийг нээсэн.

И.Ньютон инерцийн хуулиндаа хөдөлгөөний онцлог хэлбэр нь биед ямар нэгэн үйлдэл үзүүлээгүй байх үед хөдөлгөөн нь шулуун болон жигд эсвэл тайван байдаг². Учир нь хүндийн хүчний үйлдэлтэй инерцийн хөдөлгөөний холбоог тасалсан явдал... Тухайлбал нийтлэг шинж нь орон зай, цаг хугацааны координатын систем, түүнд тодорхойлогдох шулуун хөдөлгөөнийг тодорхойлох хэрэгтэй болсон. Энэ инерцийн хуулийг ерөнхийлөн дүгнэснээр, механикийг огторгуйн шинжид оруулснаар координатын системийн сонголтын тухай асуудлыг шийдэх хэрэгтэй болсон. Иймээс И. Ньютон материас үл хамаарах, абсолют шинжтэй гэж үзэн, орон зай болон цаг хугацааны ойлголтыг тодорхойлох хэрэгтэй болсон. Ингэснээрээ И. Ньютон туйлын цаг хугацаа болон туйлын орон зай, цэвэр үргэлжлэлт чанар, бие биенээсээ үл хамааран оршдог мөн, ямар нэгэн гадаад зүйлд хамааралгүй, цэвэр орон зай эзлэгч чанар, өөрөөр хэлбэл үл хувирагч, биеэ даасан шинжтэй, нэг бүрчлэн эзэмшигч шинжтэй гэдгийг хүлээн зөвшөөрөөд, түүний орон зай болон цаг хугацаа нь хүнээс үл хамааран оршдог гэжээ³. Мөн И. Ньютон матери нь дангаараа хөдлөх, хөгжих чадваргүй гэж үзсэн. Түүний үзлээр, материйн оршихуйн хэлбэрүүд болох орон зай цаг хугацаа нь туйлчлагдсан, материас өөрөөс нь салангид байдаг.

Хэрвээ оршихуйд эцэс төгсгөлгүй жижиг трапецууд байдаг гэдэгт эргэлзэж болно гэвэл түүнд өнгөрсөн болон ирээдүй хоёрын хооронд аливаа цаг хугацааны завсарын өчүүхэн хэсэг болох одоо цаг, цаг хугацааны агшин оршин байдаг, гэвч хэдий тэг биш, гэдэгт эргэлзэж болохгүй⁴ гэж И.Ньютон бүтээлдээ өгүүлсэн.

И. Ньютон ямар нэгэн гадны нөлөөгүй туйлын бодит цаг хугацааг дангаар нь гаргахыг зорьсон. Энэ зорилтоо хэрэгжүүлэхийн тулд И.Ньютон өөрийнхөө "Байгалийн философийн математик эхлэлүүд" зохиолдоо

- I. Туйлын шинжтэй цаг хугацаа нь дангаараа мөн өөрийн мөн чанар, ямар нэгэн гадны харьцаагүйгээр нэгэн жигд, өөрөөр хэлбэл, үргэлжлэлт шинжтэй байдаг.
- II. Туйлын орон зай нь өөрийн мөн чанараараа харьцангуй бус хийгээд ямартай ч гэсэн гадаад байдалдаа үргэлжид хөдөлгөөнгүй, тэнцүү шинжээр тодорхойлогдож байдаг⁵ гэжээ.

Тэрээр цаг хугацаа бол туйлын, ямар нэгэн тусгаар нөхцөл байдлаас үл хамаарах, үргэлж нэгэн жигд, дангаар урсдаг⁶ болохыг онцолсон. Ньютон туйлын орон зай, туйлын цаг хугацааны ойлголтын тусламжтайгаар

¹ Там же

² Там же. с.230

³ Аскин. Я. Ф "Проблема времени, ее философское истолкование". М, 1966. с.21

⁴ Ньютон. И "Математические работы". М. 1937

⁵ "Философия естествознания". М, 1966. с. 152

⁶ "Математическая диалектика как научная система". М, 1983. с.111

байгалийг харьцангуй байдлаар танин мэдэхээс зайлсхийхийг оролдон, байгалийн ерөнхийг олохыг эрмэлзсэн ч метафизик сэтгэлгээ нь түүнийг метафизик хийсвэрлэлд, бүтэлгүйтэлд оруулсан.

Шинэ үеийн сэтгэгчидийн дотроос цаг хугацааг өөрөөр тайлбарласан сэтгэгч бол **Д. Юм** юм. Тэрээр "Хүний уг чанарын тухай тайлбар" гэсэн зохиолдоо уг асуудлыг авч үзжээ. Түүний үзлээр, цаг хугацаа нь, цаг хугацааг бүрдүүлж буй ямар нэгэн хэлбэр болсон, цаг хугацааны үл тасалдах, ар араасаа цуврал шинж юм.

Тэрээр "цаг хугацааны агшнууд нь зэрэгцэн орших боломжгүй. Жишээ нь: 1737 онд болсон учир явдал 1738 онд давхцах боломжгүй, агшин бүр бие биенээсээ ялгаатай байх ёстой"¹ гэж цаг хугацааны үл тасалдах, үргэлжлэлт шинжийг өгүүлсэн. **Д. Юм** цаг хугацааны талаар, түүнийг гүйцэд тодорхойлохын тулд бусад ойлголтуудыг ашигласан. Мөн цаг хугацааны үзэл санаа бидний бүхий л төрлийн хүртэхүй, сэтгэгдлүүдийн дэс дараалалт шинжээс үүссэн² хэмээн үзээд, хэрвээ мэдрэгдэж буй объектуудын илт байдлыг орон зай гэж хүлээн зөвшөөрөх юм бол дэс дараалалт шинжтэй санаа болон сэтгэгдэл цаг хугацааг гарган ойлгож болно.³

Цаг хугацааг **Д. Юм** дангаараа хэзээ ч оюун ухаанд өгөгддөггүй эсвэл бидэнд ил гарч ирэх боломжгүйг хүлээн зөвшөөрөөд: хүн гүнзгий бясалгалд нойрсож байхдаа, эсвэл ямар нэгэн юманд анхаарлаа гүн төвлөрүүлэн ажиллахдаа цаг хугацаа нь их эсвэл бага хурдтай байгааг, мөн урт эсвэл богино гэж хэлэгдэх үргэлжлэлт шинжийн зохицолыг мэдрэх боломжгүйг өгүүлсэн.

Мөн тэрээр "Цаг хугацааны үргэлжлэлт шинж нь тусгаар хэсгүүдээс бүрддэг нь илэрхий бөгөөд бид өөртөө илүү удаан эсвэл илүү богино үргэлжлэлтэй шинжтэй байна гэдгийг төсөөлж чаддаггүй. Тэрчлэн тэдгээр хэсгүүд нь зэрэгцэн оршдоггүй бөгөөд зэрэгцэн оршин буй хэсгүүдийн шинж нь орон зайтай байдаг бөгөөд тэр чанараараа үргэлжлэлт шинжээс ялгарч байдаг"⁴ хэмээн орон зай болон цаг хугацааны шинж онцлогийг гарган, цаг хугацаа бол хүн зэрэгцэн орших хэсгүүдээс бүрддэг бөгөөд үл өөрчлөгдөгч объектоос гагцхүү зэрэгцэн оршихуйн сэтгэгдэл л гардаг, харин бидэнд цаг хугацааны талаарх өгсөн тийм сэтгэгдэл, үүсэн гардаггүй⁵ хэмээн илүү тодруулсан.

Дээрх өгүүлсэн цаг хугацааны оршихуйн үл давхцах хэсгүүдтэй байдаг гэх санаа нь хувиран буй объектуудын дэс дараалалтайн шинжээс урган гарсан байх ёстой гэсэн дүгнэлтийг **Д. Юм** гаргаад, тэрхүү цаг хугацааны үзэгдэл нь хувирагч объектуудын дэс дараалалт шинжтэй холбоотой оюун ухаанд л өгөгддөгийг тодорхойлсон.

Философийн түүхэнд онцлог эргэлт хийсэн сэтгэгч бол Германы сонгодог философийг үндэслэгч **И. Кант** юм. Тэрээр уран дархны гэр бүлээс гаралтай бөгөөд философи, байгалийн шинжлэх ухаан болон математик судалж чамгүй амжилт гаргасан⁶ **И. Кант** олон тооны бүтээл

¹ Юм. Д "Трактат о человеческой природе". Минск, 1998. с.90

² Там же. С.94

³ Там же

⁴ Юм. Д "Трактат о человеческой природе". Минск, 1998. с.95

⁵ Там же

⁶ "Философский энциклопедический словарь". М, 1999. с.197

туурвисаны сацуу тэрээр "Цэвэр оюун ухааныг шүүн шинжлэхүй" зохиолоо 1781 онд бичиж, тэр зохиолдоо танин мэдэхүйн онол болон метафизикийн ойлголтуудыг агуулгад нь өөрчилж оруулсан. Мөн уг зохиолдоо И. Кант цаг хугацааны талаар өгүүлсэн буй.

И. Кантын үзлээр, цаг хугацаа бол ямар нэгэн туршлагаас гаралтай эмпирик ойлголт биш¹ бөгөөд И. Кант орон зай болон цаг хугацааны уг чанарын талаархи асуудлыг шийдэхэд анхаарлаа хандуулан, орон зай, цаг хугацаа гэж юу вэ? хэмээн тэр асуугаад: Хэрвээ юмс бясалгаж ойлгодоггүй бол орон зай болон цаг хугацаа нь мөн чанарын бодит байдал, эсвэл тодорхойлолтын гол утга нь эсвэл дангаараа эд юмсад зуршмал байдаг юмсын харьцаа юмуу? эсвэл орон зай цаг хугацааны тодорхойлолт эсвэл, бясалгалын, зөвхөн зуршлын хэлбэр, харьцаа болох эдгээр предикатгүйгээр нэг ч юмсыг нэмж өгүүлэх боломжгүй байсан, бидний санааны обьектив уг чанар уу?² хэмээн асуугаад И. Кант үүндээ субъектив идеалист үзэл бодлын үүднээс хариулт өгсөн.

"Цаг хугацаа нь орон зайн адил мэдрэн хүртэхүйн априори хэлбэрээр харагддаг" хэмээгээд, Кант цаг хугацааны ойлголтын талаар метафизик тайлбарлалуудыг өгсөн байдаг. Тэрээр уг тайлбарлалдаа цаг хугацааг туршлагаас гаралтай эмпирик ойлголт бишийг дурдаад, үнэндээ хэрэв цаг хугацааны тухай априори төсөөлөл бий болоогүй л бол нэг хугацаанд байх шинж эсвэл дэс дараалалт шинж нь үл ойлгогдох зүйл³. Цааш нь Кант цаг хугацааны уг чанарын талаар хэлэхдээ: "Цаг хугацаа бол бүхий л бясалгалын үндсэн дээр оршин тогтнодог чухал төсөөлөл"⁴ гэж онцлон дурдаад, бид ямар нэгэн үйл хэргийг хийж байхдаа, бид цаг хугацааны тааламжтай үзэгдлийг ялгаж болдог ч цаг хугацааг өөрийг нь арилгаж чадахгүй. Иймээс цаг хугацаа бол априори байдлаар л өгөгддөг. Гагцхүү түүнд бүхий л үзэгдлийн бодит байдлын боломжууд л байдаг. Бүх үзэгдлийг арилгаж болох ч цаг хугацааг өөрийг нь арилгаж үл болно⁵ гэж цаг хугацааг тайлбарласан. Цаг хугацаа нь агшин бүр нэгэн зэрэг харин дэс дараалалтайгаар (орон зай нь үүний эсрэг дэс дараалалт бус харин нэгэн зэрэг) оршин байдаг⁶ гэж ялгаж өгсөн.

Дээрх өгүүлсэн үндэслэгээ нь туршлагаас гаралтай гэж болохгүй, учир нь туршлага бол ямар ч чанд хатуу нийтлэг шинжтэй, аподиктический үнэн магадлалт шинжийг өгдөггүй. Туршлагын үндсэн дээр бид зөвхөн зуршмал байдаг ойлголтыг л гэрчилдэгийг хэлж чадах ч гагцхүү тийм байх ёстой гэдгийг баталж чадахгүй⁷ гэж цаг хугацааг хэрхэн үндэслэх, туршлагаар цаг хугацааг тодорхойлж болохгүйг И.Кант тайлбарласан байна. Мөн цаг хугацааг ойлголт биш, харин цэвэр мэдрэхүйн, бясалгалын хэлбэр гэж үзэн цаг хугацаа нь нэгэн агшинд зэрэгцэн орших боломжгүй гэсэн энэ санаа нь ямар нэгэн ерөнхий ойлголтоос гараагүй. Энэ синтетик байдал нь зөвхөн

¹ Кант.И "Критика чистого разума". М, 1999. с.54

² Аскин. Я. Ф "Проблема времени, ее философское истолкование". М, 1966. с.12-13

³ Кант.И "Критика чистого разума". М, 1999. с.54-55

⁴ Там же.с. 55

⁵ Там же

⁶ Там же

⁷ Там же

ойлголтуудын нэгээс үүсэх боломжгүй, иймээс тэр нь цаг хугацааны бясалгал болон түүний тухай төсөөлөлд л шууд агуулагддаг¹.

Цаг хугацааны төгсгөлгүй шинжийн талаар Кант ямар нэгэн хэмжээ, хязгаарлаж болохгүйг дурдаад, түүний үндсэнд хязгааргүй байдал л өгөгдөх ёстойг онцолсон байдаг. Хэрвээ түүнийг дурын тоогоор хэсэг болгон хязгаарлах замаар тодорхойлж төсөөлөх боломжтой гэж үзэх юм бол бүхэлдээ төсөөлөл маань ойлголтод өгөгдөх боломжгүй (учир нь ойлголт зөвхөн төсөөлөлд харъяалагдсан байдаг) болох юм. Ойлголтын үндсэнд дам бус бясалгал байх ёстойг² уг бүтээлдээ өгүүлсэн. Ийнхүү И. Кант цаг хугацааг хүний дотоод бясалгалд өгөгддөгийг онцлон өгүүлээд, харин орон зайг гадаад үзэгдлүүдийн априори нөхцөл болохынх нь хувьд аливаагаар гадаад бясалгалын цэвэр хэлбэр гэж үзсэн. Кант цаг хугацаа дангаараа оршин байсан эсвэл юмсад зуршмал байсан зүйл биш..., цаг хугацаа нь дотоод мэдрэхүй, бидний дотоод нөхцөл байдлын болон бидний өөрсдийн ямар нэгэн мэдрэхүйн хэлбэр юм. Цаг хугацаа бол бүхий л үзэгдлийн априори хэлбэрийн нөхцөл болж байдаг³ гэсэн дүгнэлт хийсэн.

И. Кант цаг хугацааны хэсгүүдийг нэгэн зэрэг бус дараалан оршдог болохыг өгүүлээд, цаг хугацаа бол бүхий л үзэгдлийн дотоод нөхцөлд шууд өгөгддөг. Хэрвээ би априори бүхий гадаад үзэгдэл орон зайд оршдог мөн орон зайн хандлагаар априорыг тодорхойлон хэлж чадах юм бол мэдрэхүйн дотоод зарчмууд дээр тулгуурладаг нийтлэг хэлбэрийг, ер нь бүхий л үзэгдлийг, бүхий л мэдрэхүйн судлагдахуунуудыг цаг хугацаанд оршдог, гарцаагүй цаг хугацааны харьцаанд оршин байдаг гэдгийг өгүүлж чадна⁴ гэжээ.

Ийнхүү өрнийн шинэ үеийн философид цаг хугацааны талаар олон янзын үзэл баримтлал зэрэгцэн оршиж, энэхүү ойлголтын агуулгыг шинээр тайлбарласан буй.

Ном зүй

Аскин. Я. Ф "Проблема времени, ее философское истолкование". М, 1966.

История философии. т II. Огизгосполиздат, 1941.

Кант. И "Критика чистого разума". М, 1999.

Соколов. В. В "Европейская философия XV-XVII веков". М, 1984.

Философия естествознания. М, 1966.

Философский энциклопедический словарь. М, 1999.

Юм. Д "Трактат о человеческой природе". Минск, 1998

¹ Кант. И "Критика чистого разума". М, 1999. с. 55

² Там же

³ Там же. с. 56-57

⁴ Там же. с. 59